



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 18 өдөр


Дугаар 198

Улаанбаатар хот

Г Тусгай зөвшөөрөл олгох тухай Г

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 /нэг/ хуулийн этгээдэд “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосугай.
- Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 09 дугээр сарын 18-ны өдрийн
198 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Бид мон корп ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс –АНУ/	2025.09.18	2030.09.18

----- оОо -----